



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020

Э-сонин

10-Р САР

87-р дугаар






Зах зээлийн тойм


/2020.10.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	21
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	7,923,884,882
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	2,892,978,652
Хөрөнгө орцлалтын сан /анхдагч/	4,750,000,000
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	215,105,700
Компанийн бонд /хоёрдогч/	65,800,530
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	75,623,145
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	26,118,520
Хөрөнгө орцлалтын сан /анхдагч/	47,500,000
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	2,003,967
Компанийн бонд /хоёрдогч/	658
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	6,527


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	194
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	167
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс:	
Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.10.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	АРД СЕКЮРИТИЗ ХХК	42,540,559.00	4,633,530,936.25	50,221,536.00	5,402,775,315.72	10,036,306,251.97
2	БИДИСЕК ХК	14,460,656.00	1,621,156,019.23	11,330,209.00	1,383,092,800.67	3,004,248,819.90
3	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	3,784,022.00	424,821,128.48	497,290.00	57,939,993.08	482,761,121.56
4	БУМБАТ-АЛТАЙ ХХК	686,090.00	96,237,055.01	7,109,570.00	339,812,003.08	436,049,058.09
5	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	2,182,392.00	226,632,084.91	701,013.00	84,932,329.54	311,564,414.45
6	ГҮҮДСЕК ХХК	6,444,229.00	287,400,033.83	22,246.00	9,940,958.00	297,340,991.83
7	АРД КАПИТАЛ ГРУПП ХХК	556,463.00	57,441,187.73	2,934,958.00	192,856,805.97	250,297,993.70
8	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	1,574,110.00	158,791,523.04	1,021,666.00	82,291,786.82	241,083,309.86
9	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	1,337,069.00	115,302,506.10	460,697.00	36,567,27.87	151,869,933.97
10	ГАУЛИ ХХК	126,283.00	20,386,869.58	216,908.00	107,611,623.00	127,998,492.58
11	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	703,355.00	71,515,477.80	384,179.00	49,227,976.90	120,743,454.70
12	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	139,959.00	66,566,664.00	117,498.00	27,529,868.76	94,096,532.76
13	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	176,492.00	41,935,681.20	25,891.00	9,839,647.66	51,775,328.86
14	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	8,374.00	2,835,790.00	212,176.00	35,359,090.00	38,194,880.00
15	ЗЭРГЭД ХХК	113,710.00	17,665,862.86	53,076.00	13,830,258.00	31,496,120.86
16	ЦЕНТРАЛ СЕКЮРИТИЙЗ ҮЦК	15,471.00	6,049,598.25	151,005.00	24,287,823.87	30,337,422.12
17	МОНСЕК ХХК	308,017.00	17,081,370.53	23,485.00	6,036,784.30	23,118,154.83
18	ГАЦУУРТ ТРЕЙД ХХК	38,992.00	16,666,804.00	9,215.00	5,197,045.00	21,863,849.00
19	ЭС ЖИ КАПИТАЛ ХХК	0	0	38,680.00	16,519,200.00	16,519,200.00
20	ДЭЛГЭРХАНГАЙ СЕКЮРИТИЗ ХХК	70.00	1,197,000.00	7,149.00	9,906,349.00	11,103,349.00

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.10.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	7,425,089	325,278,673	88.00	85.55	2.12
2	BODI	БОДЬ ДААТГАЛ	6,271,311	708,507,433	128.00	107.10	4.93
3	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	4,709,610	447,368,243	88.00	73.50	-16.48
4	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	3,572,021	230,637,879	67.46	63.02	-5.08
5	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,003,967	215,105,700	115.00	100.11	11.87
6	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1,081,318	31,497,975	30.50	28.50	1.31
7	MFC	МОНОС ХҮНС	635,441	43,226,035	71.00	65.52	-2.86
8	NEH	ДАРХАН НЭХИЙ	550,945	8,005,814	15.00	14.00	-0.60
9	ITLS	АЙТҮҮЛС	424,936	31,920,648	79.48	74.00	-3.41
10	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	394,495	531,543,259	1,399.00	1,280.00	-2.17
11	APU	АПУ	205,962	117,057,943	577.00	559.00	-0.09
12	GOV	ГОВЬ	209,754	41,372,299	202.00	192.00	-1.61
13	TUM	ТҮМЭН ШУВУУТ	134,467	20,549,511	160.00	150.01	-3.75
14	SUU	СҮҮ	95,164	20,177,302	215.00	203.00	-2.31
15	AIC	АРД ДААТГАЛ ХК	55,425	38,909,778	714.00	673.00	1.78
16	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	47,936	65,234,881	1,550.00	1,200.00	-4.66
17	BUK	УБ-БУК	45,740	19,578,252	441.00	400.00	-8.13
18	MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	41,487	7,672,164	194.79	180.00	-5.04
19	AMT	ЭРДЭНЭС СОЛБЮШИНС	38,910	16,619,900	440.00	420.00	-6.67
20	RMC	РЕМИКОН	36,505	893,295	27.00	23.11	-12.49



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.10.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-10-01	2020-10-31		
1	БЭРХ УУЛ ХХК	3,031	375.00	598.01	223.01	59.47
2	МЕРЕКС ХХК	1,499	12.00	19.00	7.00	58.33
3	ДАРХАН ХҮНС ХХК	10	2560.00	3,379.00	819.00	31.99
4	ТАЛЫН ГАЛ ХХК	350	15.87	18.25	2.38	15.00
5	ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР ХХК	50	4600.00	5,250.00	650.00	14.13
6	УВС ЧАЦАРГАНА ХХК	1	255.00	290.00	35.00	13.73
7	УЛААНСАН ХХК	1	735.00	830.00	95.00	12.93
8	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,003,967	100.00	111.87	11.87	11.87
9	ДОРНОД ХХК	1	1300.00	1,450.00	150.00	11.54
10	БАГАНУУР ХХК	185	1000.00	1,098.00	98.00	9.80
11	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХХК	3,227	615.00	666.98	51.98	8.45
12	ТАЛХ ЧИХЭР ХХК	243	14800.00	16,000.00	1,200.00	8.11
13	Э-ТРАНС ЛОЖИСТИК ХХК	170	130.00	140.00	10.00	7.69
14	МАХИМПЕКС ХХК	990	2779.00	2,967.00	188.00	6.77
15	МОНГОЛ ШУУДАН ХХК	12,086	566.10	598.00	31.90	5.64
16	БОДЬ ДААТГАЛ ХХК	6,271,311	109.06	114.44	5.38	4.93
17	ИНВЕСКОР ХХК	4,949	2800.00	2,914.00	114.00	4.07
18	МАНДАЛ ДААТГАЛ ХХК	7,425,089	43.00	43.91	0.91	2.12
19	АРД ДААТГАЛ ХХК	55,425	687.77	700.00	12.23	1.78
20	ТАВАН ТОЛГОЙ ХХК	6,776	5705.00	5,790.00	85.00	1.49

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.10.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-10-01	2020-10-31		
1	МОНГОЛ ШЕВРО	328	1650.00	1,200.00	-450.00	-27.27
2	АВТО ИМПЕКС	175	1184.00	950.00	-234.00	-19.76
3	МАТЕРИАЛИМПЕКС	207	8495.00	7,000.00	-1,495.00	-17.60
4	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	250	2300.00	1,900.00	-400.00	-17.39
5	МОГОЙН ГОЛ	775	7500.00	6,200.00	-1,300.00	-17.33
6	ЖЕНКО ТҮР БҮРО	4,709,610	88.00	73.50	-14.50	-16.48
7	МОНГОЛ НЭХМЭЛ	97	2100.00	1,801.00	-299.00	-14.24
8	МИК ХОЛДИНГ	5,064	12790.00	11,000.00	-1,790.00	-14.00
9	ГУТАЛ	70	19800.00	17,100.00	-2,700.00	-13.64
10	ОЛЛОО	200	52.00	45.00	-7.00	-13.46
11	РЕМИКОН	36,505	26.90	23.54	-3.36	-12.49
12	ОРХОНДАЛАЙ	20	1700.00	1,500.00	-200.00	-11.76
13	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	115	419.90	375.00	-44.90	-10.69
14	МОНГОЛ ШИЛТГЭЭН	2,981	235.00	210.08	-24.92	-10.60
15	ХИШИГ УУЛ	109	500.00	450.00	-50.00	-10.00



**"ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН" ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫГ НЭЭХ
ЁСЛОЛ 10-Р САРЫН 05-НД БОЛЛОО**



Монголын хөрөнгийн биржийн шинэ бүтээгдэхүүн, анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох "Үндэсний Хувьчлалын Сан"-гийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 10 сарын 05-ний өдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Байгалмаа, "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг, "Үндэсний хувьчлалын сан"-гийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа болон бусад төлөөлөгчид оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6245 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай тус арга хэмжээг нээх үеэрээ "30 жил хувьцаа, бонд гэсэн хоёрхон төрлийн бүтээгдэхүүнтэй байсан хөрөнгийн зах зээлд анх удаа хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг олон нийтэд санал болгож буй түүхэн үйл явдал өнөөдөр тохиож байна. Иргэд хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулснаар эрсдлээ тараан байршуулах, мэргэжлийн удирдлагаар хангагдах зэрэг олон давуу талууд үүсэх юм. Нэгж эрхээ олон нийтэд анхлан санал болгож буй энэ сангийн араас олон шинэ хөрөнгө оруулалтын сангууд нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийг улам идэвхжүүлэн хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна" гэв.

Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь нийт нэгж эрхийнхээ 95 хувь буюу 47.5 сая ширхгийг тус бүрийг нь 100 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаж, нийт 4.75 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх бөгөөд тус хөрөнгөөр дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийж, түүнээс бий болох ашгийг хөрөнгө оруулагчдадаа ногдол ашиг хэлбэрээр хуваарилах юм.

Хөрөнгө оруулагчид 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниар дамжуулан тус сангийн нэгж эрхийг захиалах боломжтой.

Үйл явдал

**"CFA RESEARCH CHALLENGE" ТЭМЦЭЭНИЙ
СУДЛАГДАХУУН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА
БОЛЛОО**

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь Монгол улсад хөрөнгийн зах зээл үүссэний 30 жилийн ойг тохиолдуулан Монголын Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээчдийн Нийгэмлэгээс 5 дахь жилдээ зохион байгуулж байгаа CFA Institute Research Challenge / Судалгааны Сорил/ тэмцээнийг хамтран зохион байгууллахаар болсон билээ. Энэ удаагийн тэмцээн 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр МХБ-ийн 6315 удаагийн үнэт цаасны арилжааг нээснээр эхэлсэн бөгөөд 6 их, дээд сургуулийн 9 баг оролцож байна.

2020 оны 10 сарын 09-ний өдөр тэмцээний судлагдахуун компани "Мандал Даатгал" ХК-ийн танилцуулгыг Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Г.Ганзориг, Хөрөнгө оруулалтын менежер Баатаржав нар Монголын Хөрөнгийн Биржийн сургалтын танхимд оролцогч оюутнуудад хийж даатгалын салбарын талаар ярилцлаа.

**"БОРНУУР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
АНХААРАЛД**

"Борнуур" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 10 сарын 16-ны өдрийн №20/1 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цагт хуралдуулахаар болсон тул нийт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт

Хуралдах газар: Төв аймгийн "Борнуур" сумын Соёлын төв

Бүртгэлийн өдөр: 2020 оны 11-р сарын 09-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Компанийн санхүүгийн болон Үйл ажиллагааны тайлан
- Ноогдол ашиг тараахгүй байх ТУЗ-ийн шийдвэр
- 2020 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, батлах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийг сонгох

Хуралтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ажлын өдрүүдэд 9:00-18:00 цагийн хооронд компанийн байранд болон өөрийн харилцдаг брокер, дилерийн компаниар дамжуулан авч болно.


Холбоо барих утас: 88222323, 89114474



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН МОБАЙЛ АПЛИКЕЙШН ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж нь гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан MN STOCKS мобайл аппликейшнийг хөрөнгийн зах зээлийн өдөр тутмын мэдээ мэдээлэл, бүртгэлтэй үнэт цаас болон гишүүн компаниудын дэлгэрэнгүй мэдээллээр баяжуулан шинэчилж, ашиглалтанд орууллаа.

Уг аппликейшний тусламжтайгаар хэрэглэгч ханшийн мэдээллийг илүү хялбараар хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэн хянах боломжтой юм. Тус аппликейшнийг ашиглахын тулд App Store эсвэл Google PlayStore сангаас "MN Stocks" гэсэн аппликейшнийг татан суулгана уу.



"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ИЙН 11.2 ХУВИЙГ ЕСБХБ ЭЗЭМШИХЭЭР БОЛЛОО

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк нь "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-д олгосон \$5 сая ам. долларын хөрвөх нөхцөлтэй зээлийн хүрээнд олгогдсон эрхээ хэрэгжүүлэн 30,043,290 ширхэг энгийн хувьцаа буюу Компанийн гаргасан болон арилжигдаж буй нийт энгийн хувьцааны 11.2%-ийг эзэмшихээр болсон байна.

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли "ЕСБХБ-ны хөрвөх нөхцөлтэй зээлийн санхүүжилтээр Баян Хөндий Алтны Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг эцэслэсэн. ЕСБХБ-ны хөрвүүлэлт болон ноён Эрик Спроттын \$15 сая канад долларын хөрөнгө оруулалт бүхий \$20 сая канад

Үйл явдал

долларын санхүүжилт нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий төслийг олборлолтын шат руу хурдацтай хөгжүүлэхэд шаардлагатай төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Компани нь 2022 онд алтны үйлдвэрлэлтийг эхлүүлэхээр төлөвлөн, Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлж, дүүргийн хэмжээнд нөөц нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна." гэж мэдэгдсэн байна.

"ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН"-ГИЙН НЭГЖ ЭРХИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА АМЖИЛТТАЙ ХААГДАЖ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА 2020.10.26-НД ЭХЭЛЛЭЭ

"Үндэсний хөрөнгө оруулалтын сан"-гийн санал болгосон нэгж эрхийн анхдагч зах зээлийн нийт захиалгыг ҮЦТХТ дахь мөнгөний үлдэгдэлтэй нийцүүлэхэд 2,245 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 5,537,565,300 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 16.5 хувиар давсан үзүүлэлт боллоо.

Компанийн ирүүлсэн төлөвлөгөөний дагуу олон нийтээс ирүүлсэн нийт 2,234 хөрөнгө оруулагчдын 3,162,565,300 төгрөгийн үнийн дүн бүхий захиалгын 500,000 төгрөг хүртэлх үнийн дүн бүхий захиалгуудыг 100 хувь биелүүлж, үлдсэн дүнг 69.1 хувиар хувь тэнцүүлэн нийлүүлэхээр болов.

Нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хөрөнгө оруулагчдын дансанд сангийн нэгж эрхийг байршуулан холбогдох мэдээллийг солилцсоны дараа буюу 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлүүлэв.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ЭЭС ХАР МОРЬ ТАЛБАЙН ӨРӨМДЛӨГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛСЭН БАЙНА

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэсэн 18,000 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар 10,000 тууш метрийн 1-р үе шатны өрөмдлөгийн 3,600 метрийн сорьцдолтын үр дүнг хүлээн авсан байна.

Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр Хар Морь хайгуулын талбайд AAD-48 газрын гадаргаас 27 метрийн гүнээс эхлэх алтны өндөр аномаль бүхий 7 метрийн бүсэд (0.2 г/т хүртэл) 30.6 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал огтолсон мөн AAD-48 цооногоос зүүн зүгт 1.25 км зайд KMT-03 сувгийн доор 29 метрийн босоо гүнд AAD-41 цооногт 10.8 г/т алтны агуулгатай 1 метрийн интервалыг огтолсон байна. Компанийн зүгээс 2-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрийг 11 сард эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN